



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/125

Шивээговь сум

Тамхи худалдан борлуулах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол "Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Шивээ Сервис ХХК-ийн Уулын цайны газрын тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай сунгасугай.

2.Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлэхийг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхзаяа)-д үүрэг болгосугай.

3.Тамхи худалдан борлуулах үйл ажиллагааг "Тамхины хяналтын тухай" хуулийн 5, 6 дугаар зүйл, "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийг тус тус мөрдөж ажиллахыг Шивээ сервис ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ж.Чинбат)-д үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхзаяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42122465



ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ

"ШИВЭЭ СЕРВИС" ХХК-ИЙН
УУЛЫН ХЭСГИЙН ГУАНЗ

(Аж ахуйн нэгжийн нэр)

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

(Үйл ажиллагааны төрөл)

1-Р БАГ

(Оршин буй хаяг)

Шивээговь сумын Засаг даргын 2020 оны 09-р сарын 01-ны өдрийн А/148 тоот захирамжийг үндэслэн тамхи худалдаалах зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгов.

2020 оны 09 сарын 01 өдөр

ЗАСАГ ДАРГА  С.ЯГААНЦЭЦЭГ